



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/08/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудит: Г.Мөнхчимэг
Утас: 261628 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК
Захирал: Ч.Мөнхтуяа
Утас: 99108763 Цахим хаяг: uwaaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Ц.ДУЛАМСҮРЭН ТАНАА

2022.02.25 № 07/369
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	316,956,014.87	263,627,631.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	0
33	АВЛАГА	250,000.00	0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	250,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	286,706,014.87	263,627,631.69
35400	Хангамжийн материал	286,706,014.87	263,627,631.69
35410	Бичиг хэргийн материал	218,773.66	64,740.00
35420	Аж ахуйн материал	351,133.00	236,250.00
35440	Түлш, шатах тослох материал	4,391,559.00	5,428,230.00
35450	Барилгын засварын материал	1,080,000.00	1,080,000.00
35460	Хүнсний материал	2,937,096.00	6,572,850.00
35470	Бусад хангамжийн материал	277,727,453.21	250,245,561.69
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	30,000,000.00	0
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	30,000,000.00	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,082,015,193.79	1,315,765,811.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,082,015,193.79	1,315,765,811.75
39200	Биет хөрөнгө	1,039,515,193.79	1,273,365,811.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	815,781,191.83	845,781,191.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,993,144.32	(78,298,882.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	173,473,373.50	454,700,143.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	-96,051,392.64	(129,920,559.59)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	141,775,930.70	138,043,960.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-49,260,844.56	(72,181,601.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,207,367.46	68,596,298.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,103,790.60	(19,949,821.82)
39214	Бусад үндсэн хөрөнгө	89,673,426.48	97,470,082.88
39215	Хуримтлагдсан элэгдэл	-41,986,924.06	(30,875,000.08)
39300	Биет бус хөрөнгө	42,500,000.00	42,400,000.04
39301	Программ хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0	(99,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,000,000.00	42,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,398,971,208.66	1,579,393,443.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	250,000.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	250,000.00	0
41300	Өглөг	250,000.00	0
41360	Бусад өглөг	250,000.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	250,000.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,398,721,208.66	1,579,393,443.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,398,721,208.66	1,579,393,443.44
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	159,944,500.00	159,944,500.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,194,945,263.46	1,375,617,498.24
51210	Өмнөх үеийн үр дүн	1,139,893,205.06	1,194,945,263.46
51220	Тайлант үеийн үр дүн	55,052,058.40	180,672,234.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,831,445.20	43,831,445.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,398,971,208.66	1,579,393,443.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	571,097,135.28	776,862,970.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,873,835.28	397,166,370.09
120	Нийтлэг татварын бус орлого	163,873,835.28	397,166,370.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,063,700.00	79,373,424.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,063,700.00	79,373,424.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	69,810,135.28	305,758,819.05
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	12,034,127.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	407,223,300.00	379,696,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	319,788,300.00	326,944,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	319,788,300.00	326,944,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,435,000.00	52,752,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,435,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	42,752,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	516,045,076.88	593,315,589.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,045,076.88	593,315,589.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,012,951.89	561,047,202.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,561,672.01	197,155,574.53
210101	Үндсэн цалин	142,343,977.90	137,135,739.80
210102	Нэмэгдэл	39,788,094.11	51,087,124.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,429,600.00	8,932,710.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,544,192.00	33,403,961.00
210201	Тэтгэврийн даатгал	16,633,208.00	23,246,366.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,956,849.00	2,592,035.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,707,180.00	2,073,628.00
210204	Ажилгүйдлийн даатгал	410,678.00	499,264.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,836,277.00	4,992,668.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,147,243.00	22,762,307.00
210301	Гэрэл, цахилгаан	20,827,243.00	20,746,636.00
210302	Түлш, халаалт	0	1,015,671.00
210303	Цэвэр, бохир ус	2,320,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,882,917.00	71,732,759.22
210401	Бичиг хэрэг	2,101,055.00	837,083.66
210402	Тээвэр, шатахуун	30,010,000.00	19,754,506.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,076,687.00	2,716,775.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	695,175.00	1,729,376.00
210408	Бараа материал акталсны зардал	0	46,695,018.56
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	303,000.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	148,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	155,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	3,077,400.00	744,000.00
210702	Дотоод албан томилолт	3,077,400.00	744,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,624,298.00	105,131,299.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	76,004,798.00	99,369,887.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	319,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	52,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	247,500.00
210807	Газрын төлбөр	0	2,142,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,872,229.88	130,117,301.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,141,088.00	1,914,246.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,941,624.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,789,517.88	128,203,055.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,032,124.99	32,268,387.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	13,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	13,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,032,124.99	18,768,387.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,029,124.99	18,768,387.47
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	55,052,058.40	183,547,380.11
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	2,875,145.33
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	2,875,145.33
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	55,052,058.40	180,672,234.78

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,139,893,205.06	1,343,669,150.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,139,893,205.06	1,343,669,150.26
5	Тайлант үеийн үр дүн	-	-	55,052,058.40	55,052,058.40
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,194,945,263.46	1,398,721,208.66
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,194,945,263.46	1,398,721,208.66
12	Тайлант үеийн үр дүн	-	-	180,672,234.78	180,672,234.78
13	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,375,617,498.24	1,579,393,443.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	501,580,520.00	459,320,024.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,357,220.00	79,373,424.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,357,220.00	79,373,424.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,357,220.00	79,373,424.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,357,220.00	79,373,424.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	407,223,300.00	379,946,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	319,788,300.00	326,944,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	319,788,300.00	326,944,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,435,000.00	53,002,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	250,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	87,435,000.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	42,752,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	457,646,120.00	430,250,024.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	457,646,120.00	430,250,024.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,363,995.01	397,981,636.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,561,672.01	197,155,574.53
210101	Үндсэн цалин	142,343,977.90	137,135,739.80
210102	Нэмэгдэл	39,788,094.11	51,087,124.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,429,600.00	8,932,710.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,544,192.00	25,321,978.00
210201	Тэтгэврийн даатгал	16,823,392.00	17,511,669.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,930,100.00	1,952,578.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,544,100.00	1,562,062.00
210204	Ажилгүйдлийн даатгал	386,100.00	390,514.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,860,500.00	3,905,155.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,147,243.00	22,762,307.00
210301	Гэрэл, цахилгаан	11,183,100.00	12,492,000.00
210302	Түлш, халаалт	9,644,143.00	8,240,307.00
210303	Цэвэр, бохир ус	2,320,000.00	2,030,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,854,059.00	24,006,518.00
210401	Бичиг хэрэг	763,459.00	649,311.00
210402	Тээвэр, шатахуун	28,400,900.00	19,519,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,600.00	2,435,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,709,100.00	1,401,907.00
2105	Норматив зардал	346,500.00	346,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,500.00	346,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	148,000.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	148,000.00	0
2107	Томилолт, зочны зардал	3,077,400.00	744,000.00
210702	Дотоод албан томилолт	3,077,400.00	744,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,489,929.00	127,644,759.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,870,429.00	122,065,347.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	319,912.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	49,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	0	1,960,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,195,000.00	0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,195,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,282,124.99	32,268,387.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	13,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	13,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,282,124.99	18,768,387.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,029,124.99	18,768,387.47
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	253,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	43,934,400.00	29,070,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	43,934,400.00	29,070,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,934,400.00	29,070,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	43,934,400.00	29,070,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	43,934,400.00	29,070,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(43,934,400.00)	(29,070,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	392,444,600.00	387,549,636.53	4,894,963.47	98.8
УРСГАЛ ЗАРДАЛ	392,444,600.00	387,549,636.53	4,894,963.47	98.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,444,600.00	387,549,636.53	4,894,963.47	98.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,339,700.00	197,155,574.53	2,184,125.47	98.9
Үндсэн цалин	137,839,400.00	137,135,739.80	703,660.20	99.5
Нэмэгдэл	52,070,700.00	51,087,124.73	983,575.27	98.1
Унаа хоолны хөнгөлөлт	9,429,600.00	8,932,710.00	496,890.00	94.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,910,900.00	25,321,978.00	1,588,922.00	94.1
Тэтгэврийн даатгал	18,937,300.00	17,511,669.00	1,425,631.00	92.5
Тэтгэмжийн даатгал	1,993,400.00	1,952,578.00	40,822.00	98.0
ҮОМШӨ-ний даатгал	1,594,700.00	1,562,062.00	32,638.00	98.0
Ажилгүйдлийн даатгал	398,700.00	390,514.00	8,186.00	97.9
Эрүүл мэндийн даатгал	3,986,800.00	3,905,155.00	81,645.00	98.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,222,600.00	22,762,307.00	460,293.00	98.0
Гэрэл, цахилгаан	12,492,000.00	12,492,000.00	0.00	100.0
Түлш, халаалт	8,680,500.00	8,240,307.00	440,193.00	94.9
Цэвэр, бохир ус	2,050,100.00	2,030,000.00	20,100.00	99.0
Хангамж, бараа материалын зардал	24,056,000.00	24,006,518.00	49,482.00	99.8
Бичиг хэрэг	649,400.00	649,311.00	89.00	100.0
Тээвэр, шатахуун	19,519,700.00	19,519,700.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,435,600.00	2,435,600.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,451,300.00	1,401,907.00	49,393.00	96.6
Норматив зардал	346,500.00	346,500.00	0.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,500.00	346,500.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	118,500.00	0	118,500.00	0.0
Багаж, техник, хэрэгсэл	118,500.00	0	118,500.00	0.0
Томилолт, зочны зардал	1,205,900.00	744,000.00	461,900.00	61.7
Дотоод албан томилолт	1,205,900.00	744,000.00	461,900.00	61.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,244,500.00	117,212,759.00	31,741.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,665,000.00	111,633,347.00	31,653.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	319,912.00	88.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	49,500.00	49,500.00	0.00	100.0

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	1,960,000.00	1,960,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	392,444,600.00	387,549,636.53	4,894,963.47	98.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,944,600.00	308,176,212.53	18,768,387.47	94.3
Улсын төсвөөс санхүүжих	326,944,600.00	308,176,212.53	18,768,387.47	94.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	65,500,000.00	79,373,424.00	(13,873,424.00)	121.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,500,000.00	79,373,424.00	(13,873,424.00)	121.2
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	17	17	0.00	100.0
Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	13	13	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	3	3	0.00	100.0

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана гэж заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгадагч байгууллагад анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Уваа уул аудит” ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Уваа Уул Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 22/14 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгалийн өвөрмөц тогтоц, экосистемийн онцлог төрх, байгалийн үзэгдэл, үйл явц болон нийслэл хотын ундны цэвэр усны нөөцийг хамгаалах, бүх нийтийн экологийн мэдлэгийг дээшлүүлж, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах”-д оршино.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Нагал хааны байгалийн нөөц газрын хилийн зааг болон хил доторх газар нутгийн байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, шинжлэн судлах, зүй зохистой ашиглахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг БОАЖС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 516,045.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,160.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 180,422.3 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	250.0	0.0	(250.0)
Бараа материал	316,706.0	263,627.6	(53,078.3)
Үндсэн хөрөнгө	1,082,015.2	1,315,765.8	233,750.6
Нийт хөрөнгө	1,398,971.2	1,579,393.4	180,422.2
Өр төлбөр	250.0	0.0	(250.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,398,721.2	1,579,393.4	180,672.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,398,971.2	1,579,393.4	180,422.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 263,627.6 мянган төгрөг болж 53,078.4 мянган төгрөгөөр буурсан бусад хангамжийн материалыг акталж данснаас хассан.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,315,765.8 мянган төгрөг болж 233,750.6 мянган төгрөгөөр өссөн нь Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 281,226.8 мянган төгрөгийн үнэ бүхий 6 ширхэг авто тээврийн хэрэгсэл шилжүүлсэн авсан.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,398,721.2 мянган төгрөг болж, 180,422.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 506,384.8 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 70,500.0 мянга, нийт 576,884.8 мянган төгрөгөөр, үүнээс урсгал зардалд 576,884.8 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 184,440.2 мянган төгрөгөөр бууруулан 392,444.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд улсын төсвөөс 326,944.6 мянган төгрөг, өөрийн орлого 65,500.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 326,944.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 322,049.6 мянган төгрөгийг зарцуулж, 4,895.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, өөрийн орлогын 65,500.0 мянган төгрөгийн төлөвлөгөөнөөс 79,373.4 мянган төгрөгийн орлого орж 13,873.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 387,549.6 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3,772.9 мянга, тогтмол зардал, томилолтын зардлыг 1,122.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	392,444.6	387,549.6	4,895.0	98.8
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	226,279.6	207,542.9	18,736.7	91.7
1.1.1	12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	54,500.0	68,373.4	(13,873.4)	125.5
1.2	80219	Харуул, хамгаалалтын зардал	2,880.0	2,880.0	-	100.0
1.3	80221	Гэрээт ажиллагсдын зардал	56,250.1	56,250.1	-	100.0
1.3.1	12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	11,000.0	11,000.0	-	100.0

1.4	81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	29,771.5	29,745.2	26.3	99.9
1.5	81703	Ургамал хамгааллын зардал	11,763.4	11,758.1	5.3	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын 25 арга хэмжээний биелэлт 85.9 хувь буюу байгууллагын төсвийн гүйцэтгэл 98.8 хувийн биелэлттэй, 12.9 хувь буюу 50,625.4 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 86.5 хувиар буюу 56,625.4 мянган төгрөгөөр давж биелүүлэн үүнээс 42,752.0 мянган төгрөгийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал, мөн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” тушаалын дагуу зарцуулж үлдсэн 13,873.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 онд нийт 542,130.4 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 131,636.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 9 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 131,636.5 мянган төгрөгийн 8 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 10,876.7 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй зөрчилд 1 албан шаардлагын биелэлт 100 хувь, 17,037.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Зөвлөмж	3	17,037.8	3	17,037.8	-	-	66.6
Нийт дүн	4	17,037.8	4	17,037.8	-	-	83.3

Үндсэн хөрөнгийн ангиллыг дахин хянаж, стандарт болон бодлогын баримт бичигт нийцэхгүй зүйлсийг тодруулж, үндсэн хөрөнгөөс хасаж, бараа материалд шилжүүлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүсэлт өгч шийдвэрлүүлэх, зөвлөмжийг хэрэгжүүлсэн ба Ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичиг болон нэвтрэх хураамжийн орлогыг цаг тухай бүрд нь харилцах дансанд тушааж хэвших зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 930.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 930.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 930.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдал 5,160.5 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.3 Албан шаардлага

Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй "Ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичиг"-н 2020 оны 9-10 дугаар саруудад бичсэн үнэт цаасны орлогыг 2021 оны 1-2 дугаар саруудын хооронд тушаасан мөн "Модны эрхийн бичиг"-ийн орлогыг тухай бүр дансанд хийлгээгүй бэлнээр авч 1-2 сарын дараа өөрийн дансанд тушаасан байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Жолоочийн замын хуудас бүрэн бичилт хийгдээгүй хариуцсан албан тушаалтны гарын үсэг зурж баталгаажуулаагүй, 930.0 мянган төгрөгийн тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.6-д Анхан шатны баримтын үнэн

зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. гэж заасантай тус нийцэхгүй, толилуулга, тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг иж бүрэн хангаж, тооцоо бодолтыг үнэн зөв гүйцэтгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

[illegible]

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	ГТБЦГХЗ	АХГ- 2022/08/НА- СТА-ТШЗ	"Ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичиг", "Модны эрхийн бичиг"-ийн орлогыг тухай бүр дансанд хийлгээгүй бэлнээр авч 1-2 сарын дараа өөрийн дансанд тушаасан	Өмнөх аудитын өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчлийг даван гаргасан тул албан шаардлага өгөв	1						1	-				
Дүн					2	930.0	-	-	-	-	1	-	-	-	1	930.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 105/10170074
1017-2022/60/114-000-743

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичгийн 2020 оны 9-10 дугаар саруудад бичсэн үнэт цаасны орлогыг 2021 оны 1, 2 дугаар сард модны эрхийн бичгийн орлогыг бэлнээр авч, 1-2 сарын дараа Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогыг тухай бүр харилцах дансанд төвлөрүүлж, үнэт цаасны төлбөр тооцоог хянаж байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Ц.Дуламсүрэн, нягтлан бодогч Б.Гандолгор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Г.МӨНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-154.Docx

0010800547